



“МОНГОЛИАН ФАЙНЭНШЛ  
ПАРТНЕРС ББСБ” ХХК-Д

## САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
Бага тойруу 3, Засгийн газрын IV байр,  
Утас: 26-44-44, Факс: (976-11) 32-90-84,  
E-mail: [info@frc.mn](mailto:info@frc.mn), <http://www.frc.mn>

2022.04.13 № ЦМ-7/044 .

танай 2022.03.14 -ны № 22/07 -т

Хаяг, байршлын өөрчлөлтийг  
бүртгэсэн тухай

Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3 дахь хэсэг болон Санхүүгийн зохицуулах хорооны 2016 оны 71 дүгээр тогтоолоор баталсан “Банк бус санхүүгийн үйл ажиллагааны зохицуулалтын журам”-ын 6.2 дахь хэсгийн дагуу танай хаяг байршлын өөрчлөлтийг бүртгүүлэх тухай хүсэлтийг хянаж “Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Жигжиджавын гудамж-3, Бодь цамхаг, 11 давхар, 1100 тоот” хаягт байрлаж байсныг “Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, 13-р хороолол /14210/, Олимпийн гудамж 4-р барилга, 13 давхар, 1 тоот” гэж шинэчлэн бүртгэсэн болно.

Мөн Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.3.11-д заасны дагуу банк бус санхүүгийн байгууллагын хаяг байршлыг өөрчлөх зөвшөөрөл олгоход төлбөл зохих 10,000 /арван мянга/ төгрөгийг Төрийн сан банканд дахь Санхүүгийн зохицуулах хорооны 100900025002 тоот дансанд тушаасан баримт, хаягийн өөрчлөлтийг улсын бүртгэлийн гэрчилгээ, дүрэм, тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хавсралтад тэмдэглэгээг хийлгэсэн хуулбарын хамтаар Санхүүгийн зохицуулах хороонд ажлын 10 хоногийн дотор ирүүлэхийг үүгээр мэдэгдэж байна.

Банк бус санхүүгийн байгууллагын хаяг байршил өөрчлөгдсөнтэй холбоотойгоор харилцагч, үйлчлүүлэгчдэд сөргөөр нөлөөлөхгүй, төөрөгдүүлэхгүй байх талаар анхаарч ажиллана уу.

